

**АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ОЛОН НИЙТГЭЭС
ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН**

/2020 оны 3 сарын 31-ний өдрийн байдлаар/

Ард Кредит ББСБ Хувьцаат Компани нь үйл ажиллагаагаа өргөтгөн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх үүднээс IPO хийж нийт 5,285 сая төгрөг олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулахаар үнэт цаасны танилцуулгад тусгасан. Компани нь хувьцааны борлуулалтаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг үндсэн зээлийн үйлчилгээгээ нэмэгдүүлэх болон шинээр нэвтрүүлж байгаа “Ард” аппликэйшн, хувьцаа барьцаалсан зээлийн үйлчилгээг нэвтрүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн. Доорх зээлийн бүтээгдэхүүнүүдэд дараах дүнгээр санхүүжилт хийхээр төсөвлөсөн.

Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ	Зарцуулах дүн (мянган төгрөг)	Эзлэх хувь хувь
Бизнесийн зээл	2,768,500₮	56.5%
Хэрэглээний зээл	612,500₮	12.5%
Шуурхай зээл	980,000₮	20.0%
Кредит карт	367,500₮	7.5%
Ард аппликэйшн /Fast Cash/	49,000₮	1.0%
Хувьцаа барьцаалсан зээл	122,500₮	2.5%
Нийт	4,900,000₮	100.0%

2019 оны 3-р сараас татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах хүснэгтийн дагуу зарцуулагдсан бөгөөд санхүүжилтийн 89 хувийг үндсэн санхүүжилт болох зээлийн олголтод зарцуулсан.

Зарцлын төрөл	Зарцуулах дүн (мянган тогрог)
Маркетингийн зардал	205,566₮
Мэргэжлийн байгууллагуудын төлбөр, шимтгэл, хураамж	276,505₮
Хэвлэл танилцуулганы зардал	54,461₮
Зээл олголт	4,748,466₮
Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө	5,285,000₮

Зээлийн бүтээгдэхүүний олголт зориулалтын дагуу хийгдэж, дараах зээлийн бүтээгдэхүүний дагуу олголт 3 болон 4-р саруудад хийгдсэн байна. Зээл олголтын 88 хувийг ард аппликэйшн дээр суурилсан Fast Cash зээлийн бүтээгдэхүүн эзэлж байгаа бөгөөд зээлийн бүтээгдэхүүний хувьд эрэлт өндөртэй, өндөр өгөөж бүхий санхүүгийн бүтээгдэхүүн болно.

Зээлийн төрөл	Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс олгосон зээлийн дүн (мянган тогрог)	
	3-р сар	4-р сар
ЖДБЗ		50,000₮
Ард аппликэйшн	1,948,790₮	2,234,137₮
Шуурхай зээл	240,200₮	90,000₮
Бичил бизнесийн зээл	15,000₮	45,000₮
Худалдан авалтын зээл	16,740₮	
Хувьцаа барьцаалсан зээл	30,000₮	13,800₮
30 хоногт хүү тооцохгүй зээл		7,000₮
Шугамын зээл	50,000₮	7,800₮
Нийт	2,300,730₮	2,447,737₮

2020 оны 1-р улиралд 26,611 зээлийн 18,921 сая төгрөгийн зээлийн багцтай болж, өнгөрсөн улирлаас 2.6 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 103.5 хувиар зээлийн багцаа өсгөж чадлаа. Тус улиралд 12,162 сая төгрөгийн зээлийг дараах бүтээгдэхүүнүүдэд олгосон байна.

Бүтээгдэхүүн	Олголын дүн /мянган төгрөгөөр/
Хэрэглээний зээл	109,500₮
Жижиг дунд бизнесийн зээл	651,578₮
Тусгай нөхцөлт зээл	66,000₮
Итгэлцэл барьцаалсан зээл	62,000₮
Fast cash	10,602,167₮
Шуурхай зээл	359,250₮
Худалдан авалтын зээл	9,000₮
Цалингийн зээл	63,280₮
30 хоногт хүү тооцохгүй зээл	13,000₮
Шугамын зээл	225,000₮
НИЙТ	12,160,775

Мөн давхардсан тоогоор 73.9 мянган зээлийн 12,507 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдэж, 1 дүгээр улиралд дараах байдалтай орж ирсэн.

	Эргэн төлөлт /мянган төгрөгөөр/
I сар	4,155,509
II сар	4,577,277
III сар	3,774,978
НИЙТ	12,507,764

Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагаа буюу хүү болон шимтгэлийн орлогоос 1,889 сая төгрөгийн орлого олж, хүүгийн зардалд 477 сая төгрөг, эрсдэлийн сангийн зардалд 289 сая төгрөг, удирдлага, үйл ажиллагааны зардалд 836 сая төгрөгийг зарцуулан, тайлант хугацаанд 306 сая төгрөгийн ашигтайгаар ажиллалаа.